



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/22

Хажуу шинэ-Ус

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, Малын эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.2.1 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Морьт багийн нутаг “Булгийн улаан өндрийн гээг” нутаглаж байгаа малчны суурьт малын гоц халдварт Бог малын мялзан өвчний сэжигтэй шинж тэмдэг илэрсэнтэй холбогдуулан нийт малчид иргэдэд урьдчилан сэргийлж, анхааруулан голомтын бүсэд 2023 оны 4 дүгээр сарын 4-ний өдрөөс эхлэн онош баталгаажтал хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2.Мялзан өвчний шинж тэмдэг илэрсэн голомтын бүсэд малчдад зарлан мэдээлж ажиллахыг багийн Засаг дарга (Г.Батчулуун)-д, малд үзлэг хийн ариутгал халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулж ажиллахыг Мал эмнэлгийн тасаг, “Угтаал чандмань” мал эмнэлэг үйлчилгээний нэгжид даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.АРИУНАА